

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/276/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН БҮЖИНХЭН ЦЭЦЭРЛЭГИЙН
2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ц.Саранчимэг

Утас: 70272248 Цахим хаяг: saranchimegts@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Өлзийт экаунт аудит" ХХК

Гүйцэтгэх захирал Ч.Эрдэнэжав

Утас: 70130460 Цахим хаяг: auditulziit@gmail.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	16
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	16
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол гэмтлээс шалтгаалах өвчин
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/118

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй бөгөөд бидний мэргэжлийн шийдлийн үнэлэмжээр, сонгон авсан горимуудад алдаа болон залилангийн улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлийн үнэлгээг багтаан санхүүгийн тайланд аудитын ажлыг гүйцэтгэхэд аудитад хамгийн ихээр нөлөө үзүүлэхүйц асуудлууд нь аудитын гол асуудлууд болдог. Аудитын явцад санхүүгийн тайланг бүхэлд нь хамруулан авч үзсэн бөгөөд аудитын агуулгын хүрээнд дүгнэлт гаргахад нөлөөлсөн асуудлууд байхгүй байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал буюу нөлөө бүхий ажил гүйлгээг дараах байдлаар тодорхойлж байна.

Тайлант 75,291.8 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, санхүүгийн тайланд бүртгэж, тайлагнасан байна.

019020186

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	103,523,798.26	195,234,643.50
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	15,672,295.74	88,471,883.74
312	Банканд байгаа бэлэн мөнгө	15,672,295.74	88,471,883.74
3121	Төгрөг	15,672,295.74	84,471,883.74
31	Төрийн сангийн харилцах	15,672,295.74	84,471,883.74
35	БАРАА МАТЕРИАЛ	87,851,502.52	106,762,759.76
351	Түүхий эд материал	49,250.00	37,500.00
35130	Эм боох материал	49,250.00	37,500.00
354	Хангамжийн материал	87,802,252.52	106,725,259.76
35410	Бичиг хэргийн материал	6000.00	
35420	Аж ахуйн материал	3,084,200.00	4,288,916.08
35460	Хүнсний материал	5,755,290.00	5,212,322.00
35470	Бусад хангамжийн материал	78,956,762.52	97,224,021.68
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,401,608,251.59	1,358,020,304.93
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,401,608,251.59	1,358,020,304.93
392	Биет хөрөнгө	1,196,378,381.66	1,152,927,520.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,258,342,621.09	1,262,639,521.09
39202	Хуримтлагдсан элэгдэл	(145,591,202.96)	(203,590,645.28)
39205	Машин тоног төхөөрөмж	72,979,331.90	84,023,596.99
39206	Хуримтлагдсан элэгдэл	(19,129,041.20)	(31,187,144.91)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	56,256,908.74	79,590,658.74
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,480,235.91)	(38,548,466.63)
393	Биет бус хөрөнгө	205,229,869.93	205,092,784.93
39301	Программ хангамж	880,800.00	880,800.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(125,930.07)	(263,015.07)
39303	Бусад биет бус хөрөнгө	204,475,000.00	204,475,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,505,132,049.85	1,553,254,948.43
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,505,132,049.85	1,553,254,948.43
51	Засгийн газрын хувь оролцоо	1,505,132,049.85	1,553,254,948.43
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	529,803,122.18	529,803,122.18
51101	Өмч:-төрийн	204,475,000.00	204,475,000.00
	-хувийн	325,328,122.18	325,328,122.18
512	Хуримтлагдсан үр дүн	150,894,330.67	199,017,229.25
51210	Өмнөх үеийн үр дүн	150,894,330.67	150,894,330.67
51220	Тайлант үеийн үр дүн		48,122,898.58
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	824,434,597.00	824,434,597.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,505,132,049.85	1,553,254,948.43

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,468,417,498.85	1,230,974,109.85
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,570,877,298.85	75,291,809.85
120	Нийтлэг татварын бус орлого	1,570,877,298.85	75,291,809.85
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,570,877,298.85	75,291,809.85
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	1,570,877,298.85	36,378,715.09
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		38,913,094.76
122	Тусламжийн орлого	897,540,200.00	1,155,682.300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	684,040,100.00	982,310,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	684,040,100.00	982,310,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	32,352,100.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	32,352,100.00	0.00
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	181,148,000.00	173,371,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/орон нутгийн төсөвт байгууллага/	181,148,000.00	173,371,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	963,285,449.00	1,182,851,211.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	963,285,449.00	1,182,851,211.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	930,743,959.21	1,175,945,711.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	527,933,976.17	674,238,299.78
210101	Үндсэн цалин	377,177,541.67	465,286,167.07
210102	Нэмэгдэл	130,796,297.75	195,012,485.26
210104	Урамшуулал	19,960,136.75	13,939,647.45
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,717,613.30	84,898,798.56
210201	Тэтгэврийн даатгал	44,992,938.93	58,086,502.09
210202	Тэтгэмжийн даатгал	5,293,287.02	7,019,250.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,234,629.46	5,441,600.26
210204	Ажилгүйдлийн даатгал	1,017,887.04	1,300,393.46
210205	Эрүүл мэндийн даатгал	10,178,870.85	13,051,052.43
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	141,591,780.00	170,574,554.01
210301	Гэрэл, цахилгаан	7,588,911.00	13,363,808.75
210302	Түлш, халаалт	119,273,264.00	140,157,005.26
210303	Цэвэр, бохир ус	14,729,605.00	17,053,740.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,475,898.28	21,826,412.84
210401	Бичиг хэрэг	6,940,250.00	18,207,500.00
210408	Бараа материал акталсны зардал	2,535,648.28	3,618,912.84
2105	Норматив зардал	97,630,716.28	118,607,834.68
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,505,600	82,700.00
210502	Хоол, хүнс	84,004,590.00	110,806,428.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,120,526.28	7,718,706.68
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,476,150.00	2,250,000.00
210604	Урсгал засвар	2,476,150.00	2,250,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,403,000.00	1,786,500.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээний хөлс	1,403,000.00	1,786,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	84,514,825.18	101,763,311.75

Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,166,200.00	15,145,650.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	3,206,500.00	3,989,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	72,142,125.18	82,627,761.75
27	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,541,489.79	6,905,499.65
	Бусад урсгал шилжүүлэг	31,141,600.00	6,358,153.66
213208	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	31,141,600.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	0.00	6,358,153.66
	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,399,889.79	547,345.99
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,399,889.79	547,345.99
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	1,505,132,049.85	48,122,898.58
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,505,132,049.85	48,122,898.58

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	897,540,200.00	1,155,682,300.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	897,540,200.00	1,155,682,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	897,540,200.00	1,155,682,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	684,040,100.00	982,310,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	684,040,100.00	982,310,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	32,352,100.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	32,352,100.00	0.00
1330	Орон нутгийн төсвөөс санхүүжих	181,148,000.00	173,371,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/орон нутгийн төсөвт байгууллага/	181,148,000.00	173,371,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	879,494,904.26	1,080,221,612.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	879,494,904.26	1,080,221,612.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	846,953,414.47	1,073,316,112.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	527,933,976.13	674,238,299.78
210101	Үндсэн цалин	382,333,217.94	435,807,016.09
210102	Нэмэгдэл	125,878,875.85	223,691,752.54
210104	Урамшуулал	19,721,882.34	14,739,531.15
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,717,613.34	84,898,798.56
210201	Тэтгэврийн даатгал	44,891,471.44	57,437,312.18
210202	Тэтгэмжийн даатгал	5,281,549.60	7,052,276.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,224,959.68	5,803,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,052,995.81	1,451,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,266,636.81	13,154,710.31
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	141,591,780.00	170,574,554.01
210301	Гэрэл, цахилгаан	7,588,911.00	13,363,808.75
210302	Түлш, халаалт	119,273,264.00	140,157,005.26
210303	Цэвэр, бохир ус	14,729,605.00	17,053,740.00
2104	Хангамж, бараа материалын зардал	103,500	0.00
210401	Бичиг хэрэг	103,500	0.00
2105	Норматив зардал	87,151,445.00	110,263,460.00
210502	Хоол, хүнс	87,151,445.00	110,263,460.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,768,000.00	1,723,500.00
210604	Урсгал засвар	2,768,000.00	1,723,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,403,000.00	1,786,500.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээний хөлс	1,403,000.00	1,786,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,284,100.00	29,831,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,914,600.00	23,959,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,369,500.00	5,871,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,541,489.79	6,905,499.65
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,141,600.00	6,358,153.66
213208	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	31,141,600.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	0.00	6,358,153.66
	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,399,889.79	547,345.99
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,399,889.79	547,345.99

Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	18,045,295.74	75,460,688.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,373,000.00	2,661,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,373,000.00	2,661,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,373,000.00	2,661,100.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,373,000.00	2,661,100.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(2,373,000.00)	(2,661,100.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	15,672,295.74	72,799,588.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	15,672,295.74
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	15,672,295.74	88,471,883.74

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	529,803,122.18	828,326,649.00	(38,986,087.60)	1,319,143,683.58
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(1,315,251,631.58)	(1,315,251,631.58)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	529,803,122.18	828,326,649.00	(1,354,237,719.18)	3,892,052.00
Тайлант үеийн үр дүн			1,505,132,049.85	1,505,132,049.85
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	529,803,122.18	824,434,597.00	150,894,330.67	1,505,132,049.85
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн	529,803,122.18	824,434,597.00	150,894,330.67	1,505,132,049.85
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Тайлант үеийн үр дүн / цэвэр ашиг алдагдал/			48,122,898.58	48,122,898.58
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	529,803,122.18	824,434,597.00	199,017,229.25	1,553,254,948.43

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		15,672,295.74	(15,672,295.74)	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,171,354,600.00	1,082,882,712.00	88,471,888.00	92.4%
УРСГАЛ ЗАРДАЛ	1,171,354,600.00	1,082,882,712.00	88,471,888.00	92.4%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,164,993,800.00	1,075,977,212.35	89,016,587.65	92.4%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	738,787,100.00	674,238,299.78	64,548,800.22	91.3%
Үндсэн цалин	469,180,400.00	435,807,016.09	33,373,383.91	92.9%
Нэмэгдэл	253,676,200.00	223,691,752.54	29,984,447.46	88.2%
Урамшуулал	15,930,500.00	14,739,531.15	1,190,968.85	92.5%
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	92,330,700.00	84,898,798.56	7,431,901.44	92.0%
Тэтгэврийн даатгал	62,784,200.00	57,437,312.18	5,346,887.82	91.5%
Тэтгэмжийн даатгал	7,386,700.00	7,052,276.07	334,423.93	95.5%
ҮОМШӨ-ний даатгал	5,909,100.00	5,803,200.00	105,900.00	98.2%
Ажилгүйдлийн даатгал	1,477,800.00	1,451,300.00	26,500.00	98.2%
Эрүүл мэндийн даатгал	14,772,900.00	13,154,710.31	1,618,189.69	89.0%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	171,121,900.00	170,574,554.01	547,345.99	99.7%
Гэрэл, цахилгаан	12,419,900.00	13,363,808.75	(943,908.75)	107.6%
Түлш, халаалт	142,070,000.00	140,157,005.26	1,912,994.74	98.7%
Цэвэр, бохир ус	16,632,000.00	17,053,740.00	(421,740.00)	102.5%
Норматив зардал	126,070,900.00	110,263,460.00	15,807,440.00	87.5%
Хоол, хүнс	126,070,900.00	110,263,460.00	15,807,440.00	87.5%
Эд хогшил, урсгал засварын зардал	2,250,000.00	2,250,000.00	0.00	100%
Урсгал засвар	2,250,000.00	2,250,000.00	0.00	100%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	1,957,200.00	1,786,500.00	170,700.00	91.3%
Мэдээлэл технологийн зардал	1,957,200.00	1,786,500.00	170,700.00	91.3%
Бараа үйлчилгээний бусад зардал	32,476,000.00	31,965,600.00	510,400.00	98.4%
Бараа үйлчилгээний бусад зардал	26,604,500.00	26,094,100.00	510,400.00	98.1%
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,871,500.00	5,871,500.00		100%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,360,800.00	6,905,499.65	(544,699.65)	108.6%
Бусад урсгал шилжүүлэг	6,360,800.00	6,358,153.66	2,646.34	100.0%
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	6,360,800.00	6,358,153.66	2,646.34	100.0%
Олгосон санхүүжилт, шилжүүлэг		547,345.99	(547,345.99)	
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		547,345.99	(547,345.99)	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,171,354,600.00	1,155,682,300.00	15,672,300.00	98.7%
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	982,310,400.00	982,310,400.00		100%
Улсын төсвөөс санхүүжих	982,310,400.00	982,310,400.00		100%

Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	173,371,900.00	173,371,900.00		100%
Орон нутгийн төсвөөс	173,371,900.00	173,371,900.00		100%
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	15,672,300.00		15,672,300.00	
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	15,672,300.00		15,672,300.00	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		15,672,295.74	(15,672,295.74)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		88,471,883.74	(88,471,883.74)	
АЖИЛЛАГСДЫН ТОО	39	39		100%
Удирдах ажилтан	1	1		100%
Гүйцэтгэх ажилтан	24	24		100%
Үйлчлэх ажилтан	14	14		100%

2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	173,371,900.00	173,371,900.00		100%
УРСГАЛ ЗАРДАЛ	173,371,900.00	173,371,900.00		100%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	171,121,900.00	170,574,554.01	547,345.99	99.7%
Гэрэл, цахилгаан	12,419,900.00	13,363,808.75	(943,908.75)	107.6%
Түлш, халаалт	142,070,000.00	140,157,005.26	1,912,994.74	98.7%
Цэвэр, бохир ус	16,632,000.00	17,053,740.00	(421,740.00)	102.5%
Эд хогшил, урсгал засварын зардал	2,250,000.00	2,250,000.00	0.00	100%
Урсгал засвар	2,250,000.00	2,250,000.00	0.00	100%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		547,345.99	(547,345.99)	
Олгосон санхүүжилт, шилжүүлэг		547,345.99	(547,345.99)	
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		547,345.99	(547,345.99)	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	173,371,900.00	173,371,900.00		100%
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	173,371,900.00	173,371,900.00		100%
Орон нутгийн төсвөөс	173,371,900.00	173,371,900.00		100%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				
БАЙГУУЛЛАГЫН ТОО				
АЖИЛЛАГСДЫН ТОО	39	39		100%
Удирдах ажилтан	1	1		100%
Гүйцэтгэх ажилтан	24	24		100%
Үйлчлэх ажилтан	14	14		100%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цэцэрлэг нь эрхэм зорилгоо “Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих үйл ажиллагааг танхим болон зайны сургалтын хэлбэрийг хослуулан чанартай зохион байгуулж, хүүхдийн оюуны чадавхыг өндөржүүлэх хурд хүчний гайхамшиг спорт өрөлт тоглоомоор хөгжүүлж, эцэг, эх, асран хамгаалагчийн дэмжлэгтэйгээр хүүхэд бүрийг ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН болгон төлөвшүүлэх” гэж тодорхойлсон. Тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Анхан шатны боловсрол олгох үйл ажиллагаа

Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цэцэрлэг гүйцэтгэлийн төлөвлөгөөг 13 зорилт, хэрэгжүүлэх 42 арга хэмжээтэй баталснаас нийт 99,1 %-тай дүгнэгдсэн байна

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Шилэн дансны тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулиудыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай
- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай
- Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай (батлагдсан:2022.11.04, хэрэгжиж эхлэх:2023.03.01)
- Монгол Улсын үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай
- Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас тайлант онд төлөвлөгөөт хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цэцэрлэгийн нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын 2021 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/22 тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба энэхүү баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай нийцэж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 48,122.9 мянган төгрөгөөр буюу 1,1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	15,672.3	88,471.9	72,799.6
Бараа материал	87,851.5	106,762.8	18,911.3
Үндсэн хөрөнгө	1,401,608.2	1,358,020.2	(43,588.0)
Нийт хөрөнгө	1,505,132.0	1,553,254.9	48,122.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,505,132.0	1,553,254.9	48,122.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,505,132.0	1,553,254.9	48,122.90

Дээрх хүснэгтээс харахад: Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 72,799.5 мянган төгрөгөөр өссөн нь жилийн эцэст зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүйгээс шалтгаалсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 18,911.3 мянган төгрөгөөр өссөн нь эцэг эхчүүдээс хүлээн авсан хүүхдийн ариун цэвэр, бичиг хэргийн материалыг бүртгэж эхэлсэн, мөн 38,913.1 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө данс 2023 онд барилга байгууламж 4,296.9 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 11,409.2 мянган төгрөг, тавилга эд хогшил 23,333.7 мянган төгрөгөөр нэмэгдэж, акталсан 364.9 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 526.5 мянган төгрөгийн барилга байгууламж, 1,045.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 1,089.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, үнэ төлбөргүй хүлээн авсан 36,378.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө данс нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,553,254.9 мянган төгрөг болж 48,122.8 төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвийн санхүүжилтээр 771,807.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 149,075.2 мянган төгрөг, нийт 920,882.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цэцэрлэг нь дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 250,471.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2023 оны урсгал зардлын төсвийг 1,171,354.6 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 1,171,354.6 мянган төгрөгөөс 2 удаа тодотгол хийж 1,155,682.3 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,082,882.7 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 547.4 төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,082,882.7 мянган төгрөг буюу 92,4 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1.1	81605-Эрүүл мэндийг дэмжих	2,955.7	2,955.0	0.7	100.0%
1.2	81807-Цэцэрлэгийн хүүхдийн хоол	126,070.9	110,263.5	15,807.4	87.5%
1.3	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	6,059.5	6,056.0	0	100.0%
1.4	81823-Боловсролын байгууллагын багш, ажилчдын мэргэжил дээшлүүлэх	3,595.7	3,086.0	509.7	85.8%
1.5	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	674,102.8	601,951.4	72,151.4	89.3%
1.6	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	185,198.1	185,195.4	2.7	99.9%
1.7	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	173,371.9	172,824.5	547.3	99.7%
	Дүн	1,171,354.6	1,082,331.8	89.019.2	92.4%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн нь Зуунмод сумын Бүжинхэн цэцэрлэг нь тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр нийт 295,595.6 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авахаар төлөвлөсөн. Үүнд: Хүүхдийн хоол хүнс 122,251.7 мянган төгрөгөөр нээлттэй тендер шалгаруулахаар, 25,018.7 мянган төгрөгийн бараа үйлчилгээний зардал, бичиг хэрэг, хичээл үйлдвэрлэл, төлбөр хураамжийн зардлуудыг шууд худалдан авалтаар, 148,325.2 мянган төгрөгийн тогтмол зардлыг шууд гэрээ байгуулахаар тус бүр төлөвлөсөн.

Гүйцэтгэлээр 279,788.2 мянган төгрөгийн худалдан авалтыг төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааны зохих журмаар хийсэн байна. Худалдан авалтын дүн цэцэрлэгийн хүүхдийн тоо багассантай холбоотой 15,807.4 мянган төгрөгийн хоол, хүнсийг зарцуулаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цэцэрлэг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Өлзийт экаунт аудит” ХХК-ний Аудитор Ч.Эрдэнэжав гүйцэтгэж, чанарын хяналтыг Чанарын хяналтын менежер Ц.Бямбажав нар хэрэгжүүлж, дараагийн хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цэцэрлэг нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Өлзийт экаунт аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 24 -ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 963,285.2 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 14,449.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 10,836.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус цэцэрлэг нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гараагүй, өглөг үүсгээгүй, төсвийн хөрөнгийг зарцуулахдаа байр ашиглалтын зардлыг 547.3 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн үйлчилгээний төлбөр 170.7 мянган төгрөг, бараа ажил үйлчилгээний зардал 510.4 мянган төгрөг нийт 1,228.4 мянган төгрөгийг хэмнэлттэй зарцуулан ажилласан байна.

Судалгааны үр дүн, нөхцөл байдлын талаар бичих

Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цэцэрлэг бүртгэлд байгаа үндсэн хөрөнгө болон цалин хөлс, урамшуулал, байр ашиглалт, эрүүл мэндийг дэмжих, хүүхдийн хоол, багшийн мэргэжил дээшлүүлэх, цахим хэрэглээ, хэрэгжиж буй төсөл арга хэмжээтэй холбоотой 8 судалгааг ирүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 159 төрийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд Төсвийн шууд захирагчийн мэдээлбэл зохих 159 мэдээллээс, 2 мэдээллийн хугацаа болоогүй, хугацаа хоцроон байршуулсан мэдээлэл байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай *нийцсэн* гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй тул нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цэцэрлэгийн эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 акт, 1 албан шаардлага, 2 зөвлөмж, 1 өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 09-ны өдрийн 24 тоот албан тоотоор хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	305.3	1	305.3	100%
Албан шаардлага	1	3,474.5	1	3,474.5	100%
Зөвлөмж	2	27,683.7	1	27,683.7	100%
Нийт дүн	4	31,463.5	4	31,463.5	100%

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цэцэрлэгт дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Залруулсан алдаа

Аудитаар нийт 2,766,632.7 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн эхний үлдэгдэл 1,505,132.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2. Тайлант жилийн эд хөрөнгийн тооллогын үр дүнг хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлтэй тулгаж нэгтгээгүй, илтгэх хуудсыг хянаж хүлээн аваагүй 1,259,653.2 мянган төгрөг байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1-д “Үндсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийн тооллогоор бэлэн байгаа үлдэгдэл, нягтлан бодох бүртгэлээр байвал зохих үлдэгдлийн хоорондын зөрүүг дор дурдсан журмаар тохируулан тооцно” гэсэн заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

3. Цалингийн тооцооны хүснэгтийг НДШ тайлан, ХАОАТ-ын тайлан, санхүүгийн тайлантай тулган шалгахад 1,847.5 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-т “Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ:”, Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-т “суутгасан татварыг хуульд заасан хугацаанд харьяа татварын албанд үнэн зөв тайлагнах”, Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т “Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 4 дэх хэсэгт заасан даатгуулагч болон ажил олгогч нь дор дурдсан хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Аудитаар анхан шатны баримтын бүрдэл хангаагүй 2,615.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлэв.

5.1 Албан шаардлага

Цахим төлбөрийн баримтын системтэй тулган шалгахад 2,615.0 мянган төгрөгийн и баримтын бүрдэл хангаагүй гүйлгээ хийгдсэн нь НӨАТ-ын тухай хуулийн 4.1.13-д "нэмэгдсэн өртгийн албан татварын падаан" гэж тухайн төлбөр тооцоо хийснийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар, албан татвар суутган төлөгчийн буюу худалдаа эрхлэгч, худалдан авагч албан татвар суутган төлөгчийн нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримт", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д " нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах, эрх ба үүрэг байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлагналтай холбоотой алдаа	1	1,505,132.0			1	1,505,132.0	1	1,505,132.0				
Хөрөнгийн тооллогын дүн нэгтгээгүй	1	1,259,653.2			1	1,259,653.0	1	1,259,653.0				
НДШ, ХХОАТ-ын тайлан цалингийн тооцооны хүснэгтээр зөрүү	1	1,847.5			1	1,847.5	1	1,847.5			-	-
Дүн	3	2,766,632.7			3	2,766,632.7	3	2,766,632.7			-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Анхан шатны баримтын бүрдэл хангаагүй	1	2,615.0			1	2,615.0						



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 85-17225502-ТӨА-2024/276/НА-СТА-ТШЗ

Зуунмод

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цогцолбор цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Анхан шатны баримтын бүрдэл дутуу 1,615,000.00 төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэн байна.

Энэ нь НӨАТ-ын тухай хуулийн 4.1.13-д "нэмэгдсэн өртгийн албан татварын падаан" гэж тухайн төлбөр тооцоо хийснийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар, албан татвар суутган төлөгчийн буюу худалдаа эрхлэгч, худалдан авагч албан татвар суутган төлөгчийн нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримт", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасныг, Санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Худалдан авалт хийсэн цаг тухайд нь НӨАТ-ын баримтад бүртгүүлж сар бүрийн 10-ны дотор бэлтгэн нийлүүлэгчтэй НӨАТ-ын тулгалт хийх, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, албан шаардлагын биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цогцолбор цэцэрлэгийн эрхлэгч Ч.Ганпүрэв, нягтлан бодогч Д.Мөнхтуяа нарт даалгав.



АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ийн
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ч.ЭРДЭНЭЖАВ